



**ИНВЕСКОР ББСБ ХК**  
2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



## Агуулга

Компанийн тухай	03
2019 оны онцлох үйл явдлууд	05
Бизнесийн үйл ажиллагаа	07
Санхүүгийн үйл ажиллагаа	12
Компанийн засаглал	15
Хувьцааны мэдээлэл	18

## Компанийн тухай

Инвескор санхүүгийн байгууллага нь бичил санхүүгийн зах зээлд дэвшилтэт технологи, шинэлэг шуурхай үйлчилгээг нэвтрүүлж, харилцагчдынхаа санхүүгийн “хариуцлагатай дэмжигч” байх зорилготойгоор 2016 онд байгуулагдсан. Одоогоор Улаанбаатар хотод ББСБ-ын чиглэлээр 12 салбар, Эрдэнэт хотод 1 салбар, Япон болон Киргиз улсуудад тус тус 1 салбар компанитайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Бид цаашдаа Зүүн өмнөд Ази, Төв Азийн зах зээлд үйл ажиллагаагаа тэлж, бичил санхүүгийн үйлчилгээгээ өргөжүүлэхээр ажиллаж байна.

## Бизнесийн зарчим

Зөв засаглал

Зөв санхүүжилт

Зөв бүтээгдэхүүн үйлчилгээ



Зөв ур чадвар

Зөв хөрөнгө оруулалт

Зөв үйлчилгээний стандарт

### Эрхэм зорилго

Бид харилцагчиддаа санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, шуурхай үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлж, хариуцлагатай санхүүгийн дэмжигч байх болно.

### Алсын хараа

Бид хөгжиж буй улсуудын бичил санхүүгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, шуурхай үйлчилгээг нэвтрүүлж, иргэд болон жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжсэн хариуцлагатай санхүүг бий болгоно.

## Гүйцэтгэх захирлын мэндчилгээ



Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч нартаа энэ өдрийн мэндийг хүргэе!

Бид байгуулагдсан цагаасаа эхлэн Банк санхүүгийн салбарт ажиллаж байсан туршлагатай, ур чадвар өндөртэй хамт олныг бүрдүүлж, тэдгээр залуусын ихийг бүтээх хүсэл, тэмүүлэл, зорилготой хамт хөгжин, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, шинэлэг, шуурхай бүтээгдэхүүн үйлчилгээг Финтектэй хослуулан хөгжүүлж, салбартаа үлгэр жишээч, манлайлагч байхын төлөө ажиллаж байгаа билээ.

Манай байгууллагын 2016, 2019 оны санхүүгийн үзүүлэлтүүдийг харьцуулан харвал актив 18 дахин өсч нийт 82 тэрбум төгрөг, зээлийн багц 15 дахин өсч нийт 62 тэрбум төгрөг, мөн өөрийн хөрөнгө 17 дахин өсч 41 тэрбум төгрөгт хүрсэн үзүүлэлтийг гаргаж салбартаа тэргүүлээ. Түүнчлэн, нийт 15 салбараар дамжуулан 12 мянган харилцагчид хүрч ажиллаж байна. Үүнээс, Улаанбаатар хотод 12, Эрдэнэт хотод 1, Япон улсад 1, Бүгд Найрамдах Киргиз улсад 1 салбартай, нийт группийн хэмжээнд 150 гаруй ажилчидтай болсон нь өмнөх онтой харьцуулахад ажлын байрыг 121-ээр нэмэгдүүлсэн үзүүлэлт юм.

Бидний хувьд статистик тоон үзүүлэлт гэхээс илүүтэйгээр технологийн дэвшлийг бүтээгдэхүүндээ нэвтрүүлж, харилцагчдын орлогод нийцсэн зээлийн бүтээгдэхүүн гарган санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэн ажиллаж байгаа, мөн засаглал сайтай, ёс зүйтэй бизнесийг эрхэмлэн ажилладаг болохыг онцолж байна.

Өнгөрсөн онд, Монголын хөрөнгийн бирж дээр IPO гарган хөрөнгийн зах зээлээс 18.6 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн нь манай байгууллагад нэр төрийн хэрэг болсноос гадна Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд хувийн хэвшлийн хамгийн том IPO гаргаснаараа онцлогтой. Хувьцаагаа олон нийтэд санал болгосон энэхүү үйл явдалд гадаадын мэргэжлийн урт хугацааны стратегийн хөрөнгө оруулагчид оролцсоноороо Монголын зах зээлд шинэ гарцыг нээж, дотоодын компанийн чадамж, чансааг олон улсад харуулж чадсан үйл явдал болсон юм.

Бид олон улс руу үйл ажиллагаагаа тэлэх зорилгодоо хүрч, Төв Азийн төлөөлөл болсон Киргиз улсад салбараа нээн, өөрсдийн мэдлэг, туршлагаа зөвхөн эх орондоо биш, гадны хөгжиж буй орнуудад таниулах, цаашлаад урт хугацаанд тогтвортой үргэлжлэх бизнес болгохын төлөө хичээнгүйлэн ажиллаж байна.

Бид бусад санхүүгийн байгууллагууд, финтек компаниудтай хамтран ажиллаж улс орондоо төдийгүй гадаадад ч мэдлэг чадвар, туршлагаа бодит бизнес болгохын төлөө ажиллахаар эрмэлзэлтэй байна. Түүнчлэн цаашдаа Зүүн Өмнөд Ази, Төв Азийн зах зээлд үйл ажиллагаагаа тэлж, бичил санхүүгийн үйлчилгээгээ өргөжүүлэхээр шаргуу ажиллаж байна.

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид танд эрүүл энх, ажлын өндөр амжилтыг хүсэхийн зэрэгцээ Инвескорын хамт олонтой ирээдүйн их амжилтын төлөө хамтдаа урагшилна гэдэгт итгэлтэй байна.

Хүндэтгэсэн,

Гүйцэтгэх захирал  
Д.Баясгалан

## 2019 оны онцлох үйл явдлууд

2019

### Хамгийн таатай оффис:

Unread Media-аас шалгаруулдаг “Улаанбаатарын хамгийн таатай оффис-2019” жагсаалтад багтлаа.

#UNREAD

mintos

### ENTREPRENEUR 2019:

МҮХАҮТ жил бүр зохион байгуулдаг ENTREPRENEUR 2019: Шилдэг ББСБ-аар 3 дахь жилдээ дараалан шалгарлаа.

2019

МТБ

IPO  
PROFESSIONAL CHOICE

### МИНТОС:

Дэлхийн томоохон краудфанд платформын нэг болох Минтос компанийн шалгуурт А- үнэлгээ авч тэнцэн, хамтран ажиллахаар боллоо. Тус үнэлгээг авснаар Европын төдийгүй олон улсын хөрөнгө оруулагчдад хүлээн зөвшөөрөгдөж, харьцангуй бага зардлаар их хэмжээний санхүүжилт босгох боломжтой болж байгаа юм.

### ТОП ТАТВАР ТӨЛӨГЧ:

Чингэлтэй дүүргийн 2017, 2018 оны ТОП ТАТВАР ТӨЛӨГЧ байгууллага боллоо.

### IPO:

2019 онд хувьцаат компани болж хувийн хэвшлийн хамгийн өндөр дүнтэй нийт 18.6 тэрбум төгрөгийн үнэт цаас худалдан авах санал ирүүлж, анхдагч зах зээлийн арилжаа нийлүүлэлтээсээ давж амжилттай хаагдсан. Үүнээс 15%-ийг олон нийтэд, 85%-ийг стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгон арилжаалсан бөгөөд гадаад хөрөнгө оруулалт болон гадны эх үүсвэрийг Монголдоо оруулж ирсэн.

**Pocket аппликейшн:**

“Инвескор” Санхүүгийн группын шинэ аппликейшн “Pocket” хөгжүүлэлтийн ажил 2019 онд бүрэн хийгдэж 2020 оны 1 сард нээлтээ хийлээ.



pocket

MNS:INV

**Forbes Awards 2019:**

Forbes сэтгүүлээс жил бүр уламжлан зохион байгуулагддаг Forbes Mongolia Awards-2019 арга хэмжээгээр “Үйлчилгээний шилдэг байгууллага” шагналыг хүртлээ.



ХУР

InvesCore

КИРГИЗ УЛС

**MNS:INV**

Инвескор ББСБ ХК нь Бүгд Найрамдах Киргиз улсын “Золотой стандарт” санхүүгийн компанид хөрөнгө оруулах гэрээг байгууллаа. Тус гэрээгээр Инвескор ББСБ Золотой стандарт компанийн гаргасан нийт хувьцааг худалдаж авч байгаа бөгөөд 2020 ондоо багтаан финтек технологид суурилсан санхүүгийн үйлчилгээг тус улсад нэвтрүүлэхээр төлөвлөж байна.


**ХУР СИСТЕМ:**

Инвескор ББСБ ХК нь 2019 онд өндөр үр бүтээмжтэй финтек дээр суурилсан шинэ автоматжуулсан дотоодын Смарт-Лос систем болон ХУР СИСТЕМ нэвтрүүлсэн анхны ББСБ ба үүнтэй холбоотойгоор зах зээлдэх цар хүрээ, салбарын болон ажлын байрны өсөлт хийсэн.

**ИНВЕСКОР КИРГИЗ:**

Олон улсад үйл ажиллагаа явуулах хүрээнд Бүгд Найрамдах Киргиз Улсад шинэ салбар нээлээ.


# БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



## Харилцагчдын мэдээлэл

Нийт харилцагчийн тоо **10,690**

4.8 дахин өссөн



Зээл олголтын тоо

Зээл олголтын тоо **16,332**

3.4 дахин өссөн



Зээлийн багцын дүн

Зээлийн багцын дүн **62,301** /сая төгрөг/

1.8 дахин өссөн



Зээл олголтын дүн

Зээл олголтын дүн **166,880** /сая төгрөг/


2 дахин өссөн






## Зээлийн үйл ажиллагаа


Нийт зээлийн багц  
/сая төгрөг/



Хугацаа хэтэрсэн зээл  
/сая төгрөг/





Чанаргүй зээл  
/хувиар/



2019 оны зээлийн үйл ажиллагааны тайлангийн үзүүлэлтүүдийг өмнөх үетэй харьцуулахад нийт зээлийн багц 79 хувиар өсч, хугацаа хэтэрсэн зээл 35 хувиар буурч, чанаргүй зээл 2.2 хувиар буурсан үзүүлэлтүүдтэй амжилттай ажиллалаа.

## Хүний нөөц



2018 оны 12 сарын 31-ны байдлаар нийт 36 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байсан ба 2019 оны 12 сарын 31-ны байдлаар нийт 65 шинэ ажилтан нэмж нийт 101 буюу 181%-аар өсчээ. Үүнээс 53.5% нь эмэгтэй, 46.5% нь эрэгтэй ажилтан тус тус эзэлж байна.

## Салбарууд



2019 оны байдлаар 7 салбар шинээр нээж нийт 15 салбартай амжилттай үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс Улаанбаатар хотод 12 салбар, орон нутагт 1 салбар, Япон болон Киргиз улсуудад тус тус 1 салбартай байна.

## Нийгмийн хариуцлага


- ✓ Хөдөө аж ахуй, газар тариалан, боловсруулах үйлдвэрлэл дэмжсэн зээл нийт 1.1 тэрбум төгрөгийн дүнтэй 103 зээлийн иргэн болон аж ахуй нэгжид олгосон байна. Энэхүү ангилалд эмийн ургамал тариалах, усалгааны систем бий болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүд орсон.
- ✓ Автомашины зээлийн бүтээгдэхүүнд “Эко” тодотголтой бүрэн цахилгаан болон hybrid хөдөлгүүртэй машинд нийт 15.5 тэрбум төгрөгийн зээлийг 1,136 зээлдэгчид хосолмол хөдөлгүүртэй автомашин худалдан авахад зориулж автомашины зээл олгосон.
- ✓ Эрүүл мэндийн салбарт зээл нийт 550 сая төгрөгийн 33 аж ахуй нэгж болон иргэнд тус тус олгоод байна.
- ✓ Оффисийн цаасны хэрэглээг багасгах, цахилгаан зарцуулалтыг хэмнэх зорилготой үйл ажиллагаандаа 2 талдаа хэвлэгчтэй Xerox брэндийн хэвлэгч төхөөрөмжийг бүх салбар, цэгүүд ашиглах болсноор хэрэглээг даруй 50 хувиар бууруулсан ба мөн шинэ салбарууддаа адил жишгээр хариуцан ажиллаж байна.
- ✓ Дижитал системийг үйл ажиллагаандаа шинээр нэвтрүүлснээр цаас ашиглах шаардлага багасгаж, хэрэглээгээ 30%-аар бууруулж чадсан.
- ✓ Цахилгааны хэрэглээг бууруулахдаа шинээр тохижуулсан төв оффисийн гэрэлтүүлгийг хамгийн сүүлийн үеийн цахилгаан бага зарцуулдаг шийдлээр шийдвэрлэсэн.
- ✓ 2019 онд голчлон залуу үеэ дэмжих зорилготойгоор нийгмийн хариуцлагын хүрээнд нийт 30 гаруй сая төгрөг хандивлаж түлхүү ажиллалаа.
- ✓ 2019 оны 12 сард нээлтээ хийсэн “Галт Шувуу” уран сайхны киног залуу үеийн хүүхдүүдэд эрүүл мэнд, урлаг спортоор үлгэр жишээ болох зорилгоор ивээн тэтгэсэн.
- ✓ 2019 оны 05-р сард МУИС-ийн нэрэмжит “Эдийн засгийн онолыг хэн сайн мэдэх вэ” сэдэвт улсын 14-р олимпиадын үндсэн ивээн тэтгэгчээр оролцсон. Тус олимпиадыг 2017 оноос эхлэн жил бүр ивээн тэтгэж байна.
- ✓ 2019 оны 8-р сард МББСБХолбооноос зохион байгуулсан “1000 цүнх” аянд голден ивээн тэтгэгчээр оролцсон. Тус арга хэмжээнд 2017 оноос эхлэн жил бүр оролцож байна.
- ✓ 2019 оны 9-р сард Олон улсын чөлөөт бөхийн өсвөрийн аварга шалгаруулах нөхөрсөг тэмцээнд ивээн тэтгэгчээр оролцсон. Тус спортын арга хэмжээнд 3 дахь жилдээ ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллаж байна.
- ✓ 2019 оны 7 сард Триатлон-2019 Улсын аварга шалгаруулах тэмцээнд ивээн тэтгэгчээр оролцсон. Тус спортийн түүхэнд хамгийн их буюу 307 тамирчин оролцсон мөн цаашид Монгол улсад илүү дэлгэрүүлэх зорилготой ивээн тэтгэлээ.
- ✓ **Харилцагчдын санхүүгийн боловсролыг сайжруулах үйл ажиллагаа**  
Санхүүгийн зөвлөгөөг 36 цагийн сургалтаар харилцагчиддаа үнэ төлбөргүйгээр олгох.
- ✓ **Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа**  
Манай байгууллага нь мод тарих, байгалийн хог цэвэрлэх үйл ажиллагааг тогтмол явуулдаг.
- ✓ Мөн, үйл ажиллагаагаа автомат болгон, үйлчлүүлэгчдийн мэдээллийг хурууны хээгээр бүртгэж цаасны хэрэглээг багасгаж байна.
- ✓ Дэлхий дахинд “Covid-19” коронавируст халдвар хурдацтай тархаж байгаа энэ үед дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор “Монгол Маск Эрдэнэт” ХХК-д 30 сая төгрөгийн хүүгүй зээлийг олголоо.

# САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА




Санхүүгийн үйл ажиллагаа


Нийт орлого  
/сая төгрөг/



Цэвэр ашиг  
/сая төгрөг/




Нийт хөрөнгө болон  
өөрийн хөрөнгө  
/сая төгрөг/



■ Нийт хөрөнгө      ■ Нийт өөрийн хөрөнгө

Нийт хөрөнгө болон  
өөрийн хөрөнгийн өгөөж  
/хувиар/



■ Нийт хөрөнгө      ■ Нийт өөрийн хөрөнгө

/мянган төгрөг/

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН	Аудитлагдсан	Аудитлагдсан	Аудитлагдсан
	2019Q4	2018Q4	2017Q4
<b>ХӨРӨНГӨ</b>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,440,168	2,297,690	1,104,182
Хөрөнгө оруулалт			
Харилцагчдад олгосон зээл-цэвэр	62,301,229	34,868,286	17,859,808
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	1,055,576	417,534	539,894
Бусад хөрөнгө	3,562,473	813,349	39,620
Өмч, барилга, тоног төхөөрөмж - цэвэр	4,942,837	303,016	82,388
Биет бус хөрөнгө - цэвэр	536,619	315,217	17,639
Хөрөнгө оруулалт - өртгөөр	3,989,710	90	-
Ашиглах эрхтэй хөрөнгө	1,494,136	-	-
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>82,322,748</b>	<b>39,015,182</b>	<b>19,643,531</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>			
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	19,933,800	10,374,108	2,507,691
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	14,515,976	13,867,446	7,897,149
Бусад санхүүгийн өр төлбөр	4,186,441	496,390	85,340
Бусад санхүүгийн бус өр төлбөр	709,656	77,504	315,960
Болзошгүй өр төлбөр	774,302	-	-
Орлогын албан татварын өглөг	980,078	305,374	-
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>41,100,253</b>	<b>25,120,822</b>	<b>10,806,140</b>
<b>ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>			
Хувьцаат капитал	16,282,237	6,096,873	6,096,873
Нэмж төлөгдсөн капитал	15,377,738	-	-
Эрсдэлийн сангийн нөөц	-	-	108,752
Хуримтлагдсан ашиг /(алдагдал)	9,562,520	7,797,487	2,631,766
<b>Нийт өөрийн хөрөнгө</b>	<b>41,222,495</b>	<b>13,894,360</b>	<b>8,837,391</b>
<b>Нийт пассив ба өөрийн хөрөнгө</b>	<b>82,322,748</b>	<b>39,015,182</b>	<b>19,643,531</b>

ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАН	Аудитлагдсан	Аудитлагдсан	Аудитлагдсан
	2019Q4	2018Q4	2017Q4
Хүү болон түүнтэй адилтгах орлого	19,359,766	10,793,828	4,476,418
Хүү болон түүнтэй адилтгах зардал	(4,072,393)	(2,572,561)	(677,856)
Түрээсийн өр төлбөрийн хүүгийн зардал	(120,367)		
<b>Хүүгийн цэвэр орлого</b>	<b>15,167,151</b>	<b>8,221,267</b>	<b>3,798,562</b>
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	666,504	324,140	166,320
Гадаад валютын арилжаа болон ханшийн тэгшитгэлийн орлого/зардал	159,123	77,917	(16,588)
<b>Хүүгийн бус орлого</b>	<b>15,992,633</b>	<b>8,623,334</b>	<b>3,948,294</b>
Ажиллагсадтай холбогдолтой зардал	(2,022,639)	(902,020)	(329,064)
Үйл ажиллагааны бусад зардал	(1,862,391)	(572,104)	(244,470)
<b>Зээлийн үнэ цэнийн бууралтын өмнөх ашиг, алдагдал</b>	<b>12,107,603</b>	<b>7,149,210</b>	<b>3,374,760</b>
Зээлийн үнэ цэнийн бууралтын зардал	(56,963)	(971,766)	(312,433)
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>12,143,245</b>	<b>6,177,434</b>	<b>3,062,327</b>
Орлогын албан татвар	(2,542,578)	(1,120,475)	(325,782)
Ирээдүйд ашиг алдагдлаар ангилагдаж болзошгүй эрсдэлийн сангийн нөөц			(108,752)
<b>Тайлант үеийн цэвэр ашиг</b>	<b>9,508,062</b>	<b>5,056,959</b>	<b>2,627,793</b>

# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



## Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд



ТУЗ-ийн дарга  
**Б.Анхболд**



ТУЗ-ийн гишүүн  
**Д.Баясгалан**



ТУЗ-ийн гишүүн  
**Р.Мөнхтөр**



ТУЗ-ийн гишүүн  
**Хирохито Намики**



ТУЗ-ийн гишүүн  
**Г.Уянгахишиг**



ТУЗ-ийн гишүүн  
**Т.Тэлмэн**



ТУЗ-ийн хараат бус гишүүн  
**Ч.Хашчулуун**



ТУЗ-ийн хараат бус гишүүн  
**Д.Энхбат**



ТУЗ-ийн хараат бус гишүүн  
**Ч.Өнөржаргал**

## Компанийн удирдлагууд



Гүйцэтгэх захирал  
**Д.Баясгалан**



Дэд захирал  
**Х.Амгаланбаатар**



Санхүү хариуцсан захирал  
**Р.Пүрэв**



Үйл ажиллагаа хариуцсан захирал  
**Ш.Эрдэнэбилэг**




Хууль, Эрдэлийн удирдлага хариуцсан захирал  
**Н.Арсланбаатар**



Салбарын удирдлага хариуцсан захирал  
**О.Давааням**



## Компанийн бүтэц



## Хувьцааны мэдээлэл

**2198**

Хаалтын ханш /төгрөг/

**37%**

Ханшийн өсөлт

**1,348,878**

Нийт арилжаалагдсан ширхэг


**2,621,849,015**

Нийт арилжаалагдсан дүн

**157,657,963,764**

Зах зээлийн үнэлгээ

## Биржийн 2019 оны 4 улирлын нийт арилжаанд эзлэх хувь



## Биржийн өдрийн дундаж арилжааны дүн

/сая төгрөг/

2019 оны 4 улирал



